

2006-2007 онд Азийн хөгжиж буй орнуудын эдийн засаг эрчимтэй өснө

Хонг Конг, БНХАУ (2006.04.06) – Олон улсын эдийн засгийн ерөнхийдөө таатай дүр зураг, эдийн засгийн удирдлага сайжрах хандлага болон газрын тосны үний өсөлтийг ажрахгүй даван туулах төлөвтэй байгаа зэргээс үзэхэд Азийн хөгжиж буй орнуудын эдийн засаг 2006 онд эрчтэй өснө гэж Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны томоохон тайлан мэдээлж байна.

Өнөөдөр БНХАУ-ын Хонг Конгод нийтэлж гаргасан АХБ-ны эдийн засгийн хамгийн чухал хэвлэл болох “Азийн хөгжлийн урьдчилсан төлөв байдал” (АХУТБ) хэмээх товхимолд өгүүлснээр 2006 онд тус бүс нутгийн эдийн засаг нийлбэр дүнгээрээ 7.2%, 2007 онд 7%-иар тус тус өсөх хандлагатай байгаа бөгөөд энэ нь 2005 оны 7.4%-иас ялимгүй бага байна.

“Дэлхийн эдийн засгийн хүчирхэг байдал нь Азийн хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч гол хүчин зүйл хэвээр байх болно” гэж Манила дахь төвтэй, олон талт хөгжлийн энэ банкны ерөнхий эдийн засагч Ифзал Али хэлсэн байна. Тэрбээр “Энэ жил аж үйлдвэрийн томоохон орнуудын эдийн засгийн өсөлт боломжит өсөлттэй ойртох хандлагатай байгаа бөгөөд дэлхийн худалдаа тогтвортой хэвээр байна” гэжээ.

Мөн “Дэлхийн зах зээл дээрх электрон барааны салбарт үргэлжилж буй өсөлт болон БНХАУ, БНЭУ-ын эдийн засгийн эрчтэй өсөлтөөс Азийн орнуудын эдийн засаг эрч хүч авна” гэжээ.

Азийн хөгжиж буй орнуудын өсөлтийн төлөв байдал нь бүс нутгийн гурван гол орон болох БНХАУ, Энэтхэг Өмнөд Солонгосоос ихээхэн шалтгаална. Эдгээр гурван орон бүс нутгийн орлогын 66%-ийг бүрдүүлдэг.

Олон жил дараалан хоёр орон тооны хувиар өсч байсан БНХАУ-ын эдийн засаг 2005 онд 9.9%-иар өсчээ. Эрчтэй өсөж буй экспорт болон хөрөнгө оруулалт хэрэгцээг өсгөсөөр байсан бөгөөд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ ч өсчээ.

Хятадын засгийн газар нь сүүлийн жилүүдийн эдийн засгийн хурдацтай өсөлтөөс үүдэн гарсан нийгмийн болон байгаль орчны зарим нэг ээдрээтэй асуудал руу анхаарлаа хандуулах зорилгоор эдийн засгийн өсөлтөө удаашруулах зорилго тавиад байна. АХУТБ-д дурьдснаар, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2006 онд 9.5% болж буурч 2007 онд улам буурч 8.8%-д хүрэх төлөвтэй байна.

Энэтхэг улсын эдийн засаг 2005 онд 8.1%-иар өссөн бөгөөд үүнд аж үйлдвэр болон үйлчилгээний салбар хурдацтай хөгжиж хөдөө аж ахуйн салбар 2004 онтой харьцуулахад сэргэж эхэлсэн нь нөлөөлжээ. 2005 онд Өмнөд Солонгосын эдийн засгийн өсөлт буурч байснаа оны сүүлчээр өргөн хэрэглээний барааны хэрэгцээ сэргэсэн нь жилийн дундаж өсөлтийг 4% хүртэл өсгөжээ.

Энэтхэг улс эдийн засгийн өсөлтөө дунд хугацаанд 9%-иас дээш гаргах зорилт дэвшүүлээд байна. Үүнд хүрэхийн тулд хөрөнгө оруулалтын ДНБ-нд эзлэх хувиа өсгөж капиталын үр ашгаа дээшлүүлэх шаардлагатай болох бөгөөд энэ хоёр зорилтын аль алиныг биелүүлэхийн тулд тууштай шинэчлэлт хийх шаардлагатай гэж АХУТБ товхимол үзэж байна.

Энэтхэгийн эдийн засгийн өсөлт 2006 оны санхүүгийн жил (СЖ)-д 7.6%, 2007 оны СЖ-д 7.8% байх төлөвтэй бөгөөд энэ нь дунд хугацааны хүлээгдэж байсан өсөлтөөс бага зэрэг доогуур байна. Өсөлт, ялангуяа хэрэглээний болон хөрөнгө оруулалтын өсөлтийг түлшний үнийн

зохицуулалт сааруулах бөгөөд энэ нь инфляцийг хөөрөгдөх хандлагатай байна. АХУТБ-д дурьдсанчлан зээлийн хүүгийн өсөлт нь хөрөнгө оруулалтанд бага зэрэг сөрөг нөлөө үзүүлэх болно.

Зүүн-Өмнөд Азийн нийлбэр өсөлт 2005 оны 5.5%-иас бараг өөрчлөгдөхгүй төлөвтэй байгаа ч энэ нь орон орны хувьд өөр өөр байх болно. Индонезийн хувьд зээлийн өндөр хүү дотоодын хэрэгцээг хязгаарлаж байгаагаас 2006 онд эдийн засгийн өсөлт нь буурах магадлалтай байхад Тайландын хувьд цунами болон муу ургацын уршиг 2005 онд багассанаас эдийн засаг нь илаарших төлөвтэй.

2005 онд Азийн хөгжиж буй орнуудын дэлхийн бусад орнуудтай хийсэн худалдааны илүүдэл нь 52 тэрбум ам. доллараар өсч 192 тэрбум ам. долларт хүрсэн бөгөөд үүнээс зөвхөн БНХАУ-ын худалдааны тэнцэл 74 тэрбум ам. доллараар өсчээ. Зүүн-Өмнөд Азийн урсгал тэнцэл нийлбэр дүнгээрээ ашигтай гарч байгаа мэт харагдаж буй боловч Филиппин болон Тайландын худалдааны алдагдал улам өсчээ. Газрын тосны үнэ өссөнөөс Дундад Азийн худалдааны ашиг 75%-иар өссөн байхад Өмнөд Азид Балбаас бусад орны хувьд худалдааны алдагдал нь өссөн байна.

АХУТБ-д тэмдэглэснээр, 2006, 2007 онд Азийн хөгжиж буй орнуудын урсгал тэнцэл их ашигтай хэвээр байх ч үүнтэй уялдаад дотоодын хэрэгцээ өсч валютын нөөцийн өсөлт саарах зэрэг зарим өөрчлөлтүүд ажиглагдаж байна.

“Дунд хугацааны хувьд Азийн эдийн засгийн өсөлт тогтвортой байх болно. Газарзүйн байршил, хүн ам зүй болон тэргүүлэх бодлого боловсруулагчид нь дэлхийн эдийн засагтай нэгдэх нь тус бүс нутгийг бэхжүүлнэ гэсэн итгэлтэй байгаа нь тус бүс нутагт таатайгаар нөлөөлж байна” гэж ноён Али хэлэв.

АХУТБ-д дурьдсанаар, Азийн хөгжиж буй орнуудад одоо ч урьдныхтай адил эрсдэлүүд тулгарч буй бөгөөд эдгээр нь харин ч илүү тодоор илрэх бололтой. Дэлхийн төлбөрийн тэнцвэрт бус байдлыг эмх замбараагүйгээр шийдвэрлэх, H5N1 вирус (шувууны ханиад) хүнд халдварлах, газрын тосны үнэ өндөр байгаа буюу худалдааны протекционизм ихсэх нь төлөв байдлыг хүндрүүлэх болно.

2006 оны АХУТБ товхимолд 43 гишүүн орны сүүлийн жилүүдийн эдийн засгийн байдлын үнэлгээ болон 2006, 2007 оны макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг тусгасан. Энэ жилийн АХУТБ товхимол нь улс орны талаарх бүлгүүдийг шинэ хэлбэрээр гаргасан бөгөөд үүнд мэдээллийн илүү өргөн график танилцуулга, тус бүс нутгийн дунд хугацааны (2006–2010) боломжууд бөгөөд саад бэрхшээлүүдийн тойм зэрэг орсон болно. Товхимолд мөн Азийн худалдааны ирээдүйн боломжуудыг судалсан ‘Азийн худалдааны чиглэл’ гэсэн тусгай бүлэг орсон болно.

Манилад төвтэй АХБ нь ядуу орнуудын эдийн засгийн тогтвортой өсөлт, нийгмийн хөгжил ба сайн засаглалыг дэмжих замаар Ази, Номхон далайн бүс нутагт ядуурлыг бууруулах зорилготой. 1966 онд байгуулагдсан энэхүү банк нь 64 гишүүнтэй бөгөөд тэдгээрийн 46 нь тус бүс нутагт оршдог улс орнууд юм. 2005 онд АХБ-наас нийт 5.8 тэрбум ам. долларын зээл болон 198.8 сая ам. долларын техникийн туслалцааг тус тус баталжээ.

Мэдээний талаар лавлагаа хэрэгтэй бол:

Dave Kruger
Tel: +0918 939-9058
E-mail: dkruger@adb.org

АХБ-ны мэдээний англи электрон хувийг:

ADB Online Media Center: media.adb.org
ADB web site: www.adb.org